# УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН ТУШААЛ

2016 оны 05 сарын 10 өдөр | Дугаар А/68 | Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах,
хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 16.5.5, Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 63 дугаар зарлиг, Ногоон байгууламжийн сангийн дүрмийн 3 дугаар хэсгийн 3.1.2, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан "Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам"-ын 2 дугаар хэсгийн 2.4.1, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9, 4 дүгээр хэсгийн 4.4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Улаанбаатар хотын хэмжээнд "Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр"-ийг 2016 оны 05 дугаар сарын 14-ний Бямба гаригт зохион байгуулах, энэ үеэр хийгдэх ажлын төлөвлөгөөг гаргаж мод, сөөг тарих, арчилгаа хийх газруудыг сонгож бэлтгэлийг хангах, энэхүү ажилд бүх дүүрэг, хороо, хэсэг, байгууллага, аж ахуйн нэгж, айл өрх, иргэдийг өргөн оролцуулах, ажлын тайлан, дүн мэдээг олон нийтэд мэдээлэх үүрэг бүхий Ажлын хэсгийг 1 дүгээр хавсралтаар, мод тарих, арчлах үйл ажиллагаанд шаардагдах зардлыг 2 дугаар хавсралтаар, таригдсан мод, сөөгний дүн, мэдээг гаргах маягтыг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. "Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр"-ийн хүрээнд хийгдэх ажилд шаардагдах нийт 49,850,000.00 /Дөчин есөн сая найман зуун тавин мянга/ төгрөгийг Ногоон байгууламжийн сан болон Хот тохижилтын төсөвлөгдсөн зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч /Д.Булган/- д зөвшөөрсүгэй .

3.Тарьсан мод, сөөгийг 3 дугаар хавсралтаар батлагдсан маягтын дагуу бүртгэлжүүлж, дүн мэдээг 05 дугаар сарын 20-ны дотор Нийслэлийн Байгаль орчин, ногоон хөгжлийн газарт ирүүлэхийг Дүүргүүдийн Дэд бүтэц, тохижилтын асуудал хариуцсан Засаг даргын орлогч нарт даалгасугай.

D:\backup_old_pc\Work documents\doc 2016\tushaal 2016.docx

1110300271

4. Мод, сөөг тарих ажлыг мэргэжлийн байгууллага, хамт олон, иргэдээр зохион байгуулалтын өндөр түвшинд гүйцэтгүүлэх, цаашдын арчилгааг эзэнжүүлэх, ажлын дүн, мэдээг тайлагнаж ажиллахыг Ажлын хэсэг/Т.Батбаяр/-т даалгасугай.

ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР БӨГӨӨД
ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА Б.БАДРАЛ

УХА0501 9077367

Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
2016 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн
А/68 тушаалын ........ хавсралт

# “БҮХ НИЙТЭЭР МОД ТАРИХ ӨДӨР”-ИЙН АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

| | | |
|---|---|---|
| Ажлын хэсгийн ахлагч: | Т.Батбаяр | Улаанбаатар хотын Захирагчийн Ажлын албаны Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтсийн дарга |
| Гишүүд: | Г.Болормаа | Нийслэлийн Байгаль орчин, ногоонхөгжлийн газрын дарга |
| | Д. Энхсайхан | Нийтийн үйлчилгээний Улаанбаатар нэгтгэл /ОНӨААТҮГ/-ийн гүйцэтгэх захирал |
| | | Дүүргүүдийн дэд бүтэц, тохижилтын асуудал хариуцсан Засаг даргын орлогч нар |
| Нарийн бичгийн дарга : | Л.Баатарцогт | Захирагчийн Ажлын албаны Ногоон байгууламж хариуцсан мэргэжилтэн |

Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
2016 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн
А/68 дугаар тушаалын 2 дугаар хавсралт

# “БҮХ НИЙТЭЭР МОД ТАРИХ ҮНДЭСНИЙ ӨДӨР”-ӨӨР ЗОХИОН БАЙГУУЛАГДАХ АЖЛУУД, ТҮҮНД ШААРДАГДАХ ЗАРДАЛ

| д/д | Хийгдэх арга хэмжээнүүд | Хариуцах байгууллага | Зардлын хэмжээ /төгрөг/ |
|---|---|---|---|
| 1. | “Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр”-ийн нээлтийн арга хэмжээг зохион байгуулах | Дүүргүүдийн ЗДТГ | |
| 2. | “Мод сөөг, тарьц суулгацын үзэсгэлэн худалдаа”-г дүүрэг бүрт зохион байгуулах | ЗАА, Дүүргүүдийн ЗДТГ | 500000 |
| 3. | НИТХ-ын ажлын алба, НЗДТГ, ЗАА,НБОНХГ-ын ажилтнууд Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд мод сөөг услах, арчлах ажилд оролцох /Бээлий 200 ш, хувин 40 ш-ийг олгох/ | Үндэсний цэцэрлэгт хүрээлэн , НЗДТГ, НИТХурал, ЗАА, НБОНХГазар | 9600000 |
| 4. | Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, эмнэлэг орчимд тарих мод сөөг олгох, тариулах арга хэмжээг зохион байгуулах /1000 ш улиас, 6000ш цагаан мод, 1085 ш монос нийт 8085 ш мод сөөг хуваарилан олгох/ | Захирагчийн Ажлын алба, дүүргүүдийн ЗДТГ<br>Дүүргүүдийн ЗДТГ | 3250000 |
| 5. | Дэвсгэр нутгийн бүх байгууллага, аж ахуйн нэгжүүдийн эзэмшил талбай, хашаанд мод, сөөг тариулах ажлыг зохион байгуулах | ЗАА, Гэр хороолол дахь ЗАА | |
| 6. | Гэр хороолол дахь Захирагчийн ажлын алба бүр өөрийн хариуцсан | Захирагчийн Ажлын | |

| | | | |
|---|---|---|---|
| | хороодын айл өрхүүдэд мод сөөг тариулах ажил зохион байгуулах / 500 ш улиас, монос 500 ш олгон тариулах/ | алба, UBS телевиз, Дүүрэг, хороод | |
| 7. | “Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр”-ийн арга хэмжээг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд сурталчлах | Нийслэлийн Байгал орчин, ногоон хөгжлийн газар | |
| 8. | Нийслэлийн харьяа бүх агентлаг, газруудын дунд мод тарих арга хэмжээнд зориулсан хандив өргөх арга хэмжээг зохион байгуулах | Нийслэлийн Байгал орчин, ногоон хөгжлийн газар,<br>Дүүргүүдийн ЗДТГ | 6500000 |
| 9. | “Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр”-өөр хотын хэмжээнд таригдсан мод, сөөгний дүнг нэгтгэн гаргах, нийтэд мэдээлэх, тарьсан мод, сөөгийг бүртгэлжүүлэх, дүнг нэгтгэн гаргах, мэдээллийн санд оруулах | ЗАА,Нийтийн үйлчилгээний Улаан-баатар нэгтгэл<br>ЗАА, Дүүргүүдийн ЗДТГ, Хороод | 3000000 |
| 10. | Нийтийн эзэмшлийн гудамж, цэцэрлэгүүдэд мод, сөөг шинээр болон нөхөн тарих | ЗАА, Дүүргийн ЗДТГ, хороод | |
| 11. | Гэр хорооллын айл өрхүүдэд жимсний болон гоёл чимэглэлийн мод, сөөг хуваарилан олгох, тариулах / монос 1000 ш, үхрийн нүд 1000 ш / | | |
| 12. | Хашаандаа мод сөөг тарьж ургуулсан айл өрхүүдийг урамшуулж жимсний мод, сөөг олгох ажлыг зохион байгуулах Үүнд: Үхрийн нүд 6670 ш, монос 2860.ш / | | |
| | Нийт дүн /сая төгрөг/ | | 49850000 |

Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2016 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн А/489 дугаар тушаалын 3 дугаар хавсралт

**Нийслэлийн хэмжээнд бүх нийтээр мод тарих өдрөөр таригдсан модны нэгдсэн мэдээ**

Дүүргийн нэр ............................

| № | Хорооны дугаар | Байршил /гудамж, цэцэрлэгийн нэр / | Талбайн хэмжээ | Модны нэр төрөл | Таригдсан модны тоо | | Мод тарьсан иргэдийн тоо | Мод тарьсан аж ахуй нэгж байгууллагын тоо | Орон нутгийн төсвөөс зарцуулсан хөрөнгийн хэмжээ | Арчилгааг хариуцах байгууллага,иргэний нэр |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | мод | Бут, сөөг | | | | |
| 1 | | | | | | | | | | |
| 2 | | | | | | | | | | |
| 3 | | | | | | | | | | |
| 4 | | | | | | | | | | |
| 5 | | | | | | | | | | |
| 6 | | | | | | | | | | |
| 7 | | | | | | | | | | |
| 8 | | | | | | | | | | |
| 9 | | | | | | | | | | |
| 10 | | | | | | | | | | |
| Нийт дүн | | | | | | | | | | |

Зөвлөмж: 1. Бүх нийтээр мод тарих өдрөөр таригдсан мод, бут сөөг нэг бүрийг эзэнжүүлж арчилгаа, усалгааг тогтмол хийлгэх,

2. Дээрх эзэнжүүлсэн мод сөөгний ургалтын хувийг намар 09-р сарын 15-25-ны дотор гаргаж дүнг НБОНХГазарт ирүүлэх,